



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10, 14 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Магадлан шалгах ажиллагааны 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн дүгнэлтийн дагуу Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээд (2)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлт оруулах арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн
104 тоот тогтоолын
хавсралт

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөр- лийн дугаар	Хамрах хүрээ, үйлчилгээний хүртээмж	Тусгай зөвшөөр- лийн хугацаа	Дуусах хугацаа
1	“Мобинет” ХХК	13400119	Монгол Улсын нутаг дэвсгэрт Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх	5 жил	2031.08.31
2	“Монголсат нэтворкс” ХХК	13300004	Монгол Улсын нутаг дэвсгэрт Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх	5 жил	2031.08.25

----- оОо -----